



ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АХМАДЫН ХОЛБОО

2020 оны 12 сарын 31 өдөр

Дугаар: 11

Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 5-р хороо
Партизаны гудамж-6
Утас: 99113154, 88013154

ОБЕГ, НОБГ, УАБ, УНС БОЛОН ТӨВ ОРОН НУТГИЙН ОБГ-ЫН АХМАДЫН ХОРОО, ЗӨВЛӨЛ, САЛБАРЫН ДАРГА НАР ТАНАА

Онцгой байдлын ерөнхий газраас 2020 онд “Ахмадын сан”-д хуваарилсан зардлын тайлан, Засгийн газрын 2017 оны 197 тогтоол, “Онцгой байдлын байгууллагын ахмад настны хөгжил, хамгаалл”-ын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2021 онд шаардагдах зардлын төсвийг хийж 2021 оны 1 дүгээр сарын 15-ны дотор ирүүлэхийг мэдэгдье.

Түүнчлэн Ахмадын хороо, зөвлөл, салбарын гишүүдийн дэлгэрэнгүй судалгааг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар шинэчлэн бүртгэж ирүүлэх хэрэгтэй байна.

ХҮНДЭТГЭСЭН:

АХМАДЫН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН



Д.ХИШИГБААТАР

“МЭДЭЭЛЭЛ - 2020”

Нэг. Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбооны удирдах зөвлөл Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоол, “Онцгой байдлын байгууллагын ахмад настны хөгжил, хамгаалал”-ын хөтөлбөр, төлөвлөө, Ахмадын холбооноос түшиглэсэн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ахмад настны нийтлэг эрх ашиг, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, ахмадуудынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ахмад настнуудыг шагнаж урамшуулах, Онцгой байдлын албаны Ахмад, дунд, залуу үеийн дөрөв дэх удаагийн чуулга уулзалтаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбооны удирдах зөвлөл 2020 онд 3 удаа хуралдаж 17 асуудлыг авч хэлэлцэн 12 тогтоол батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Ахмадын холбооны удирдах зөвлөлийн хурлаар НОБГ, ҮАБ, УНС болон 21 аймгийн ОБГ-ын Ахмадын хороо, зөвлөл, салбарын 2020 оны эхний хагас болон бүтэн жилийн ажлыг нэгтгэн дүгнэсэн байна. Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбоо 2020 онд 18 ажил хийхээр төлөвлөснөөс 15 асуудлыг бүрэн хэрэгжүүлж төлөвлөгөөний биелэлт 83.3 хувьтай байна.

Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоол, “Онцгой байдлын байгууллагын ахмад настны хөгжил, хамгаалал” хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2020 онд нэн шаардлагатай 126.5 сая төгрөгний төсөв зардлыг нэгтгэн хийж, Сангийн яаманд хянуулж 88.5 сая төгрөгөөр батлуулан ОБЕ, НОБГ, ҮАБ, УНС болон 21 аймгийн ОБГ-т хуваарилуулсан байна.

Ардын хувьсгалын 99 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 109 жилийн ойг тохиолдуулан төв орон нутгийн ОБГ-ын Ахмадын хороо, зөвлөл, салбарын 51 ахмад настанг төрийн дээд шагнал одон, медаль болон салбарын шагналаар шагнуулах саналыг авч хэлэлцэн ОБЕГ-ын даргад дэмжин уламжилсан байна.

Дээрх түүхт баярыг тохиолдуулан Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор: Н.Сандуйжав /Говь-Алтай/, Б.Гончигжамц /Завхан/ нарыг, Цэргийн гавьяаны одонгоор: О.Эрдэнэчимэг /Баянхонгор/, Ш.Нарангэрэл /Дорноговь/, Д.Доднойсүрэн, Ц.Магванренчин, Д.Сандагдорж /бүгд Өвөрхангай/, Д.Пулемёт /Сэлэнгэ/, Л.Бат-Өлзий /ҮАБ/ нарыг, Алтан гадас одонгоор: Б.Дамба-Очир /ҮАБ/, Энхцэцэг /Баянхонгор/, Х.Батсайхан /Говь-Алтай/, Ш.Чулуунбаатар /Завхан/, Ц.Сүхбаатар /Өвөрхангай/ нарыг, Цэргийн хүндэт медалиар: Ц.Мягмар, Б.Гүнчинсүрэн /бүгд Баянхонгор/, Хөдөлмөрийн хүндэт медалиар: Ю.Улаабанди нар тус тус шагнагдсан байна.

Салбарын шагналаар: Онцгой байдлын албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр: О.Олзвой /Баянхонгор/, Д.Энхбат /Булган/, О.Мөнхцэцэг /Өмнөговь/, Д.Пүрэвжав /Төв/, Л.Сүрэнжав /ОБЕГ/, Л.Нямсүх /ОБЕГ/, Б.Мөнхсүх, Н.Шар, М.Эрдэнэтуяа /Говьсүмбэр/, С.Батхуяг /НОБГ/, М.Насантогтох /ОБЕГ/, Онц гал сөнөөгч тэмдгээр: С.Мөнхжаргал, Д.Халзанням /бүгд Баянхонгор/, А.Болдбаатар /Булган/, Б.Зоригт /ҮАБ/, Ө.Амармэнд, Б.Хашчулуун /Орхон/, Ө.Баатархүү /Говьсүмбэр/ нарыг, Онцгой байдлын албаны төлөө 1, 2, 3-р зэргийн тэмдгээр: Ч.Энх-Амгалан, С.Ариунболд, С.Сэрээтэр /бүгд Булган/, Д.Болдбаатар, С.Гая, Д.Эрдэнэсан, Б.Оюун /бүгд Өмнөговь/, С.Чимэддорж /Төв/, Ё.Батбаяр, Б.Хандсүрэн /бүгд Хөвсгөл/, Д.Галцог, Д.Даваасамбуу, Б.Гончигжамц, Д.Наранцэцэг /бүгд Завхан/, нарыг тус тус шагнаж урамшуулсан байна.

Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбоо 2020 онд ОБЕГ болон харьяа төв орон нутгийн Ахмадын хороо, зөвлөл, салбараас 36 албан тоот хүлээн авч шийдвэрлэн 11 албан тоот явуулсан байна.

Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбооны харьяа Ахмадын 4 хороо, 21 зөвлөл, 2 салбарын 2020 оны эхний хагас болон бүтэн жилийн ажлыг шалгуур 8 үзүүлэлтийн дагуу дүгнэж дүнг Ахмадын холбооны удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батласан байна.

2020 оны эхний хагас жилийн ажлын тайланг НОБГ, ҮАБ, Сэлэнгэ аймгийн ОБГ-ын 3 Ахмадын хороо, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Хэнтий, Хөвсгөл аймгийн ОБГ-ын 18 Ахмадын зөвлөл, хугацаандаа ирүүлсэн байна.

2020 оны эхний хагас жилийн ажлын тайланг Ахмадын хорооноос ОБЕГ-ын төв аппарат, Ахмадын зөвлөлөөс Увс, УНС-ын "Объект-03", Ховд аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл, Ахмадын салбараас Дархан-Уул аймгийн Шарын гол суман дахь ГУА 55-р ангийн Ахмадын салбар, Улсын хүнсний нөөцийн Ахмадын салбар ирүүлээгүй байна.

НОБГ, ҮАБ, Сэлэнгэ аймгийн ОБГ-ын Ахмадын хорооны ажлыг 8 үзүүлэлтийн дагуу дүгнэхэд: НОБГ-ын Ахмадын хороо 33 оноогоор 1-р байр, ҮАБ, Сэлэнгэ аймгийн ОБГ-ын Ахмадын хороо 30 оноогоор 2-3-р байрыг тус тус эзлэсэн байна.

Ахмадын зөвлөлийн ажлыг дүгнэхэд Баянхонгор аймаг 38 оноогоор 1-р байр, Дундговь аймаг 37 оноогоор 2-р байр, Хэнтий, Завхан, Дархан-Уул аймаг 36 оноогоор 3-5-р байр, Төв, Өвөрхангай, Өмнөговь аймаг 35 оноогоор 6-8-р байр, Дорнод, Сүхбаатар аймаг 34 оноогоор 9-10-р байр, Дорноговь, Говьсүмбэр аймаг 33 оноогоор 11-12-р байр, Булган, Орхон аймаг 31 оноогоор 13-14-р байр, Архангай, Хөвсгөл аймаг 30 оноогоор 15-16-р байр, Баян-Өлгий аймаг 27 оноогоор 17-р байр, Говь-Алтай аймаг 26 оноогоор 18-р байрыг тус тус эзлэсэн байна.

Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбооны харьяа Ахмадын 4 хороо, 21 зөвлөл, 2 салбарын 2020 оны жилийн ажлыг нэгтгэн дүгнэхэд Ахмадын хорооноос ҮАБ-ын Ахмадын хороо 37 оноогоор 1-р байр, НОБГ-ын Ахмадын хороо 34 оноогоор 2-р байр, Сэлэнгэ аймгийн ОБГ-ын Ахмадын хороо 32 оноогоор 3-р байр эзлэсэн байна.

Ахмадын зөвлөлөөс Баянхонгор аймаг 39 оноогоор 1-р байр, Дундговь аймаг 38 оноогоор 2-р байр, Дорноговь аймаг 37 оноогоор 3-р байр, Булган, Өмнөговь аймаг 36 оноогоор 4-5-р байр, Говь-Алтай аймаг 35 оноогоор 6-р байр, Архангай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Хэнтий аймаг 34 оноогоор 7-12-р байр, Завхан, Орхон, Сүхбаатар, Төв, Увс, Хөвсгөл аймаг 33 оноогоор 13-18-р байр, Баян-Өлгий аймаг 30 оноогоор 19 дүгээр байрыг тус тус эзлэсэн байна.

Ахмадын салбараас Улаанбаатар хот Хүнсний салбарын Ахмадын салбар 32 оноогоор 1-р байр, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ГУА 55-р ангийн Ахмадын зөвлөл 31 оноогоор 2-р байрыг тус тус эзлэсэн байна.

2020 оны ажлын үзүүлэлтээр эхний байр эзлэсэн НОБГ, ҮАБ-ын Ахмадын хорооны дарга И.Чинбат, Д.Пүрэвдож нарыг Ахмадын холбооны Өргөмжлөл тус бүрийг 200000 төгрөгөөр, Ахмадын зөвлөлөөс 1-р байр эзлэсэн Баянхонгор аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөлийн дарга Ч.Төмөрбаатарыг Ахмадын холбооны

Өргөмжлөл 150000 төгрөгөөр, 2-р байр эзлэсэн Дундговь аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөлийн дарга Б.Бямбадоржийг Ахмадын холбооны Өргөмжлөл, 125000 төгрөгөөр, 3-р байр эзлэсэн Дархан-Уул аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөлийн дарга О.Бямбадорж, Хэнтий аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөлийн дарга Д.Цэцгээ нарын тус бүр Ахмадын холбооны Өргөмжлөл, 100000 төгрөгөөр шагнаж урамшуулахаар шийдвэрлэсэн байна.

Цаашид эхний хагас жилийн болон жилийн ажлын тайланг ажил дүгнэх 8 үзүүлэлтийн дагуу гарган ирүүлж байхыг төв орон нутгийн Ахмадын хороо, зөвлөл, салбарын дарга нарт үүрэг болголоо.

2020 оны эхний хагас жил болон бүтэн жилийн ажлын тайланг ирүүлээгүй ОБЕГ-ын төв аппаратын Ахмадын хороо, УНС-ын "Объект-03", Ховд аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөлийн дарга нарт сануулах арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн шийдвэр гарсан байна.

2020 онд ОБЕГ-ын даргын батласан түшиглэсэн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлт 83.3 хувьтай биелэсэн байна.

Ахмадын холбоо 2020 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар ОБЕГ, НОБГ, АТА, УНС-ын болон төв орон нутгийн Ахмадын хороо, зөвлөл, салбарын гишүүдийн бүртгэлийг шинэчлэн нэгтгэхэд 2301 гишүүн бүртгэгдснийг 2019 оны мөн үетэй харьцуулахад гишүүний тоо 216 ахмад настнаар нэмэгдсэн байна.

Хоёр. Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбооны санхүүгийн эх үүсвэр болох гишүүнчлэлийн татвар хураалтаас хандив болгон 2020 онд Ахмадын холбооны дүрмийн 4.1.2 дахь заалтыг үндэслэн холбооны дансанд Хэнтий аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.05.12-ны өдөр 63600₮, Говьсүмбэр аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.06.22-ны өдөр 40800₮, Өвөрхангай аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.07.16-ны өдөр 68400₮, Төв аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.07.21-ний өдөр 50000₮, Сүхбаатар аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.08.28-ны өдөр 60000₮, Баянхонгор аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.09.11-ний өдөр 50400₮, Орхон аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.09.16-ны өдөр 100000₮, Дундговь аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.09.16-ны өдөр 50000₮, Өмнөговь аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.09.16-ны өдөр 37200₮, Увс аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.09.18-ны өдөр 300000₮, Дорноговь аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.09.23-ны өдөр 56400₮, Дархан-Уул аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.09.24-ний өдөр 100000₮, Үндэсний Аврах Бригадын Ахмадын хороо 2020.09.25-ны өдөр 198000₮, Булган аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.10.05-ны өдөр 80000₮, Дорнод аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.10.09-ний өдөр 70000₮, Сэлэнгэ аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.10.22-ны өдөр 164000₮, Архангай аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.11.03-ны өдөр 68750₮, Улаанбаатар хотын Хүнсний салбарын Ахмадын салбар 2020.11.05-ны өдөр 16000₮, Хөвсгөл аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.11.10-ны өдөр 96000₮, Завхан аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.12.16-ны өдөр 54000₮, Баян-Өлгий аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2020.12.17-ны өдөр 34800₮, Дархан-Уул аймгийн Шарын гол сум дахь ГУА-55-р ангийн Ахмадын салбар 2020.12.20-ны өдөр 24000₮, НОБГ-ын Ахмадын хороо 2020.12.30-ны өдөр 684500₮, Говь-Алтай аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 2021.01.05-ны өдөр 43800₮ нийтдээ 2510650 төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Гурав. Монголын Ахмадын баярыг тохиолдуулан төв орон нутгийн ОБГ-ын удирдлага 1700 гаруй ахмад настанг, ОБЕГ-ын удирдлага 196 ахмад настныг хүлээн авч уулзан хүндэтгэл үзүүлж шагнаан урамшуулж мөн гарын бэлэг өгсөн байна.

Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбоо өвчний учир нас нөхцсөн бэлтгэл хурандаа агсан Н.Бойрой, М.Содномжамц нарын ар гэрийнхэнд нэг удаагийн буцалтгүй тусламж, эрүүл мэндийн шалтгаанаас удаан хугацаагаар өвчтэй байгаа Төв аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөлийн гишүүн Г.Нанжид, Сэлэнгэ аймгийн ОБГ-ын Ахмадын хорооны гишүүн Б.Нямаа, УНС-ийн Ахмадын зөвлөлийн гишүүн Х.Гранов нарт эмчилгээний зардалд зориулан мөнгөн тэтгэмж тус тус олгосон байна.

Түүнчлэн 19 Ахмадын хороо, зөвлөл ажлынхаа тайланг тавьж хэлэлцүүлсний дээр Сэлэнгэ аймгийн ОБГ-ын Ахмадын хороо, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөлийн бүх гишүүд дарга нараа шинээр сонгож батламжлуулахаар саналаа ирүүлсэн байна.

Дөрөв. Гэр орон нь шатсан Хөвсгөл аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөлийн гишүүн ахмад настан Б.Хасбазар, Баянхонгор аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөлийн гишүүн Д.Халзанням нарын хүсэлт өргөдлийг ОБЕГ-ын удирдлагад танилцуулж тус бүр таван ханатай гэр олгуулахаар шийдвэрлүүлсэн байна. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд Дорноговь аймгийн “Болор аграмба” ХХК тус аймгийн ОБГ-ын Ахмадын хорооны гишүүн ахмад настан Ж.жаргалмаад таван ханатай гэр олгосон байна.

Тав. Төв орон нутгийн ОБГ-ын Ахмадын хороо, зөвлөл, салбар тухайн орон нутгийн ОБГ-тай хамтран 60 гаруй ахмад настан коронавирус цар тахлын үед гудамж талбайд эрүүл жижүүрт гарах, хол хорионы постод хязгаарлалтын дэглэм сахиулах, 1000 гаруй амны хаалт оёж өөрийн алба хаагчид болон ахмад настнууддаа тараах, постод ажиллаж байгаа алба хаагчдад халуун хоол унд, аарц хүргэж өгөх ажлыг зохион байгуулсан байна. Энэ ажилд Завхан, Төв аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл илүү идэвх санаачлагатай ажилласан байна. Түүнчлэн Баянхонгор аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл 5 мянган блок цохиж, 20 гаруй тросс шүүр, 10 гаруй цохиур хийж түшиглэсэн байгууллагадаа өгсөн байна. Дорноговь аймгийн ОБГ-ын Ахмадын зөвлөл гишүүдээсээ хандив цуглуулж аймгийнхаа Онцгой комисст өгсөн байна.

Хэдийгээр коронавирус цар тахлын хол хориотой байсан боловч ихэнх аймгийн Ахмадын хороо, зөвлөл өндөр настай эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчилж байгаа ахмад настнуудад сэтгэл санааны дэм үзүүлж мөнгөн тусламж олгох, түлээ нүүрс худалдан авахад мөнгөн дэмжлэг үзүүлсэн байна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН
АХМАДЫН ХОЛБОО